

Төсөл хэрэгжүүлэгч:
“ХҮДРЭНТ” ХХК

**ДОРНОГОВЬ АЙМАГ, ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН
НУТАГТ ОРШИХ “ХОНГОР-3” ЖОНШНЫ ОРДЫГ
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2024 он

**ДОРНОГОВЬ АЙМАГ, ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХОНГОР-3” ЖОНШНЫ
ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

(Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-017256)

(Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2732521)

Хянасан: БОУАӨЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

.....

Биелэлтийг тайлагнасан:



..... Б.Мөнхбат

Улаанбаатар

2024 он

ГАРЧИГ

1. Төслийн тодорхойлолт	2
2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	5
3. Нөхөн Сэргээлтийн Төлөвлөгөөний Биелэлт	7
4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	7
5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	7
6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	7
7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	8
8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	9
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	10
10. Аймаг, сумын Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ.....	10
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	11

1. Төслийн тодорхойлолт

Төсөл хэрэгжүүлэгч: “Хүдрэнт” ХХК

- Улсын бүргэлийн дугаар: 9011054065
- Регистрийн дугаар: 2732521


Төслийн нэр: Хайлуур жоншны орд ашиглах

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар, 6-р хороо, метро бизнес төв. Утас: 99006331 .

Орд ашиглах тусгай зөвшөөрөл: “Хүдрэнт” ХХК-д АМГТХЭГ -ын 2013 оны 01-р сарын 30 -ны өдрийн шийдвэрээр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Хонгор-3 нэртэй газарт ашигт малтмал ашиглах MV-017256 дугаартай тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгосон.

Ордын нөөцийн баталгаажуулалт: ЭБМЗ-ийн 2012 оны 1-р сарын 11-ний өдрийн ХХ01-04 тоот дүгнэлт, АМГ-ын даргын 2012 оны 1-р сарын 23-ны өдрийн 46 тоот тушаалаар В+С зэрэглэлээр батлагдсан 192872 т хүдэр, 73396.1 т хайлуур жоншны нөөцийг хүлээн авсан.

Төслийн хэрэгжих байршил: MV-017256 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Хонгор-3”-ийн жоншны ордын талбай нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт оршино. Улаанбаатар хотоос зүүн урагш 330км, Сайншанд хотоос баруун урагш 130 км, Даланжаргалан сумын төвөөс урагш 20 км, төмөр замын Айраг өртөөнөөс баруун тийш 28 км зайд 24.93 га талбайг эзлэн оршино.



Зураг 1. MV-010927 тусгай зөвшөөрөлтэй талбайн байршил

Ордыг ашиглах арга

Хонгор-3 ордын боломжтой В зэрэглэлээр тогтоогдсон 1-В-1, 2-В-2 блокын нөөцийг олборлох техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд тусгав. Хүдрийн биетүүд нь 70-72° уналтай, 3.45-5.57 м зузаантай, 63-65 м гүнд тогтоогдсон байна. Захиалагч компаний техникийн даалгаврыг үндэслэн тус ордыг ил ба далд хосолсон аргаар ашиглахаар тусгалаа.

А) Ил уурхайн ашиглалтын системийн сонголт

Хонгор-3 хайлуур жоншны ордын ил аргаар ашиглах нөөцийн хэмжээ, уурхайн ашиглалтын хэтийн төлөв, ашиглалтын технологи зэргийг үндэслэн **авто тээвэртэй, гадаад овоолготой** ашиглалтын систем хэрэглэхээр төсөлд тусгав.

Б) Далд уурхайн ашиглалтын системийн сонголт

Ордын VII хүдрийн биет нь дунджаар 70-72° уналтай, нөөц тогтоосон гүн нь 60 м, хүдрийн дундаж зузаан нь 3.45-5.57 м байна. Геолог-хайгуулын ажлаар тодорхойлогдсон хүдрийн биетийн үндсэн үзүүлэлтүүдийг үндэслэн **дэд давхарын штрекээр нураах ашиглалтын систем** ашиглалтын системийг сонгох нь хамгийн тохиромжтой байна.

Ордын нөөц:

2020 оны 01 -р сарын 01 -ний байдлаар ордын хэмжээнд боломжтой В зэрэглэлээр 79492 т хүдэр, 32453.0 т хайлуур жонш, С зэрэглэлээр 97670 т хүдэр, 37647.9 т хайлуур жонш, нийт В+С зэрэглэлээр 177162 т хүдэр, 70099.9 т хайлуур жоншны нөөц байна.

Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

а) Ил уурхай

Ил уурхайн календарьчилсан төлөвлөлтийн байдлыг уулын ажлын эцсийн байдлын хүрээнд хийгдсэн тооцоо, зургуудыг үндэслэн хийв. Ил уурхайн хүрээ хязгаар дахь нөөцийг ашиглалтын эхний жилд олборлож дуусах бөгөөд сард 6737.7-8354.8 мян.м³ хөрс хуулалт, 2855-3540 т хүдэр олборлолтын ажил хийгдэх ба хөрс хуулалтын дундаж коэффициент 2.36 м³/т байна.

Хүснэгт 1. Ил уурхайн уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Улирлууд				Нийт
		I	II	III	IV	
Хөрс хуулалт	м³	24058.2	22908.2	22638.7	22027.7	91632.8
Хүдэр олборлолт	т	10107	9707	9593	9421	38827
Хөрс хуулалтын коэф	м³/т	2.38	2.36	2.36	2.34	2.36

б) Далд уурхай

“Гипроруда” хүрээлэнгийн бололвсруулсан СН-440-79-60 аргачлалаар уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөг зохиоход малталт нэвтрэлтийн хамгийн бага хурдыг баримтална. Малталтын хөндлөн огтлолын талбайн хэмжээнээс хамаарах

нэвтрэлтийн хурдны хамгийн бага үзүүлэлтийг хүсн.№ II.10-т үзүүлэв. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөг боловсруулахад дараах нөхцлүүдийг баримтлав.

Хүснэгт 2. Уулын малталт нэвтрэлтийн хурд (СН-440-79-60 нормоор)

Уулын малталт, хийгдэх ажлын төрөл	Хэмжих нэгж	Хамгийн бага хурд	
		СН-440-79-60 нормоор	Төслийн
Гол ам: - босоо	м/сар	30-35	30
Квершлаг	м/сар	60 хүртэл	30
Хээрийн штрек	м/сар	50, 65-80	60
Восстающий	м/сар	31-40, 45	1.5
Гол ам орчмын малталтууд, уулзварууд	м³/сар	350	287
Гол амны тоноглоогоо	м/сар	250	
Гол амны бэхэлгээ	м/сар	180-230	

2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжүүлсэн	Тайлбар
1. АГААРЫН ЧАНАР				
Тоосжилт үүсэх	Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн маршрутын дагуу замыг тогтмол засч янзлах	Айраг сумын жонш тээвэрлэлтийн нэгсэн маршрутын дагуу уурхайн тээвэрлэлт хийдэг кампонуудтай хамтрах	Тээвэрлэлтийн үйл ажиллагаатай уялдуулан эвдрэл гарсан тухай бүрт засч сайжруулсан /Хавсралт зураг 1/	Бүтээгдэхүүн тээврийн замын маршрут /хавсралт материал 1/
	Уурхайн замын усалгаа хийх, салхи ихтэй үед хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг хязгаарлах	Замын усалгаа, овоолго тогтворжуулах		
Утаа болон хийн бохирдол үүсэх	Машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, шаардлагатай тохиолдолд шүүлтүүр, гүйцэд исэлдүүлэх төхөөрөмж тавих	Гэмтэл гарсан тухай бүрт	Машин техникээс гарах хорт утаа, дуу чимээг намсгахын тулд Шүүлтүүр хийсэн /хавсралт зураг 2/	
	Агаарын бохирдлын тухай хуулийн дагуу техник хэрэгслийн татварыг төлөх	Хүнд даацын машин механизм болон суудлын машин техник	Жил бүр татварыг төлсөн	
2. ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ				

Дорноговь аймаг, Даланжаргалан сумын нутагт орших “Хонгор-3” жоншны ордыг ашиглах
төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хөрсний элэгдэл, эвдрэл бий болох	Дотоод зам тавих, маршрут чиглэллийг заасан тэмдэглэгээ хийх	Тогтмол хяналт тавьж, эвдрэл гарсан тухай бүрт засварлах	Дотоод замын дагууд анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулсан /хавсралт зураг 3/	
	Ногоон байгууламж арчлах	Уурхай ойр орчим болон бутлуурын талбай дахь ногоон байгууламжийг арчлах, услах	Уурхай болон бутлуурын талбайд мод, бут сөөгийг тарьсан бөгөөд үүнийг зуны улиралд байнга усалгаа, арьчилгаа хийж байна. /Хавсралт зураг 4/	тэрбум мод төслийн хүрээнд хийгдэж буй ажлыг дэмжин уурхайн орчинд 50ш улиас суулган ургуулж, 200ш улиас мод үрслүүлж бэлдэж байна. /Хавсралт материал 4/
Хөрсний үржил шим алдагдах	хөрсийг стандартын дагуу хуулж хадгалах	Төслийн хугацаанд 107.2 мян.м³ хөрс хуулж овоолго үүснэ.	Үржил шимт болон үндсэн хөрсний овоолгыг стандартын дагуу хуулж хадгалж байна /Хавсралт зураг 5/	
3. ГҮНИЙ УС				
Усны нөөц багасах, түвшин буурах	Усны эх үүсвэрийг тоолууржуулах, ТЭЗҮ-д тусгагдсан усны хэмжээг хэтрүүлэхгүй байх	Сумын засаг даргатай гэрээ байгуулан хамтран ажиллах	Ахуйн Худаг усны тоолуур шинэчлэн, ус ашиглуулах дүгнэлт гаргуулан ажиллаж байна. /Хавсралт зураг 6/	Ус ашиглах дүгнэлт /хавсралт материал 3/
	Гүний усны нөөц, түвшин зэргийг компанийн үйл ажиллагаатай уялдуулан судалгаа хийх	Умард говийн гүвээт сав газартай хамтран ажиллах	Уурхайн нөлөөлөлд байдаг гүний худгуудын усны нөөц, ундрагыг тогтмол хянахын тулд улирал тутам нэг удаа хэмжилт хийдэг. /Хавсралт зураг 7/	
Усны бохирдол	Ундны усны эх үүсвэрийг хамгаалах, засварлах	Ундны усны 1 худаг	Унд ахуйн худагт эрүүл ахуйн хамгаалалтын байр барьсан /хавсралт зураг 8/	
4. АМЬТНЫ АЙМАГ				
Амьтдын тоо толгой багасах,	Уурхайн орчим дахь зэрлэг ан амьтдын ажиглалт судалгаа хийх	Амьтдын хөдөлгөөнд тандалт хийх	Уурхай орчим намар болон өвлийн цагт 12ш аргаль ирж өвөлждөг.	

Дорноговь аймаг, Даланжаргалан сумын нутагт орших “Хонгор-3” жоншны ордыг ашиглах
төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

амьдрах орчин хумигдах			2024 он буюу сүүлийн жилүүдэд цөөрч 6-7 ш аргаль ирдэг болсон Энэ орчим өвөлждөг зэрлэг амьтдад өвс тэжээл тавьж өгдөг /Хавсралт зураг 9/	
------------------------------	--	--	--	--

3. Нөхөн Сэргээлтийн Төлөвлөгөөний Биелэлт

Энэ онд нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөгдөөгүй.

4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжилт	Тайлбар
Биотехникийн арга хэмжээ	Хужир, өвсийг байршил бүхий онцгой бүс, амьтдын гол тархац бүхий газруудыг сонгон биотехникийн ажил хийх	Их нарт байгалийн нөөц газрын албанаас бидэнд ирсэн саналын дагуу биотехникийн арга хэмжээнд санхүүгийн туслалцаа үзүүлсэн	-

5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн талбайд нүүлгэн шилжүүлэх айл өрх байхгүй тул нөхөн олговрын ажил хийгдэхгүй болно.

6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн талбайд бүртгэгдсэн түүх соёлын өв байхгүй тул хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө гараагүй

Дорноговь аймаг, Даланжаргалан сумын нутагт орших “Хонгор-3” жоншны ордыг ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн
Галын аюулгүй байдал			
1	Түлшний агуулах, автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болозошгүй	Гал түймрээс урьдчилан сэргийлэх хэрэгсэл (галын дохиолол,) болон гал гарсан тохиолдолд унтраах, хамгаалалтын багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	Шатах тослох материал хэрэглэдэг уурхайн орчинд тавигдах галын аюулаас сэргийлэх үүднээс шаардлагын дагуу галын аюулгүй ажиллагааг хангах хэрэгсэл төхөөрөмжүүдийг нэгтгэх суурилуулж ажиллах зааврын хамт байршуулсан. /Хавсралт зураг 10/
		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж цайны газар, ажилчдын тахины цэг болон бусад шаардлагатай гэсэн газарт барлуулах	
		шатах тослох материалын хадгалалт хамгаалалтыг стандартын дагуу хийж түүнтэй харьцан ажиллах ажилчдыг мэргэжлийн сургалтанд тогтмол хамруулах	Шатах тослох материалын хадгалалт хамгаалалтыг стандартын дагуу хийж байршуулсан /Хавсралт 11/
Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл			
2	Хүчтэй салхи, шороон шуурганы үед харагдах орчин хязгаарлагдах ажил зогсох	Уурхайн ажилыг түр зогсоох, машин техникийг аюулгүй байдал хангасан газар зогсоож, уурхайн нуралт, гулсалтаас сэргийлэх арга хэмжээ авах, ажилчдад аюулгүй байдлын зааварчилгаа өгөх	Байгалийн гамшигт үзэгдлийн үед авах арга хэмжээний сургалтыг тогтмол авч хэрэгжүүлж байна. -
3	Хүчтэй аадар бороо, аянга цахилгааны улмаас ажлын байрны аюулгүй байдал алдагдах, дэд бүтцийн байгууламж болон уурхайн карьер, туунаах нуур сэтрэх, үер ус буух ажилчдын гэмтэл бэртэл үүсэх	Уурхайн ажлыг түр зогсоох, их үер усыг зайлуулах суваг шуудуу татах, үерийн хамгаалалт хийх, ажилчдад аюулгүй байдлын зааварчилгаа өгөх.	
Ажилчдын санамсар болгоомжгүй үйлдэл			
1	Уурхайн тоног төхөөрөмж саатах, эвдрэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах Замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулж байх, техник хэрэгсэлд яаралтай үел ашиглах хэрэгсэл, эмийн сан тогтмол байлгах	Хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны сургалт үйл ажиллагааг тогтмол хугацаанд хийж байна. -
2	Зам маршрут өөрчилж явснаас үүдэн осол гарах санамсаргүй хоорондоо мөргөлдөх		

8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэрэгжүүлсэн
Ахуйн хатуу хог хаягдлыг хадгалах түр цэг байгуулах	Ангилан хаях зориулалттай хогийн савыг уурхайн кемп дээр байрлуулах Хог хаягдал түр хадгалах цэгийг цементээр хучих болон блокон хана босгох (салхинд хийсэхгүй байхаар)	байршуулсан Салхинд хийсэхгүй байхаар хана босгож хог хаягдлыг түр хадгалах цэгийг барьсан /Хавсралт зураг 13/
Хог хаягдлыг ангилан ялгах	Дахин ашиглагдах (шил, лааз, хуванцар, төмөр, мод, цаас) Даланжаргалан сумын түүхий эд авах цэгт нийлүүлэх –төслийн талбайгаас 15 км	Дахин ашиглагдах түүхий эдийг ангилан ялгаж түр хадгалан давихар авах цэгт нийлүүлсэн /Хавсралт зураг 12/
Ахуйн хатуу хог хаягдлыг зориулалтын цэгт нийлүүлэх (тээвэрлэх)	Уурхайд ажиллах 70 хүн өдөрт 0.5 кг хатуу хог хаягдал үүсгэнэ гэвэл 340 хоногт 11.9 тн хаягдлыг хог хаягдал тээвэрлэх эрх бүхий байгууллалатай хамтран ажиллаж хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлнэ. Шаардлагатай тохиолдолд тухай бүр	Ахуйн хог хаягдлаа Олон овоотын хогийн цэгт тээвэрлэж хаядаг /Хавсралт зураг 14/
Бие засах газрыг сайжруулсан нүхэн жорлон барих эсвэл бага оврын цэвэрлэх байгууламж барих	Нэг хүн өдөрт 200 гр өтгөн ялгаруулж, 1.2 л шингэн гаргадаг гэж үзвэл урхайн 70 ажилчин жилд 680 кг өтгөн, 4080 л шингэн гаргахаар байна. Үүнийг сайжруулсан нүхэн жорлон 5924:2015 стандартын дагуу шийдэх	MNS5924:2015 “Нүхэн жорлон, угаадасны нүхний техникийн шаардлага”-д нийцсэн, байгальд ээлтэй арга хэлбэрээр ариун цэврийн байгууламжийг барьсан /Хавсралт зураг 15/
Шатах тослох материалын хаягдал зориулалтын саванд цуглуулж, хадгалах	Шатах тослох материалын үлдэгдлийг зориулалтын саванд цуглуулж хадгалах, зохих байгууллагад нийлүүлэх.	Аюултай хог хаягдлыг стандартын дагуу тусгай цементлэсэн талбайд байрлуулж цуглуулж, зохих байгууллагад тушаадаг. 2024 оноос ЖҮД ЖИ ЖИГДЭН ХХК-тай гэрээ байгуулж хамтран ажилласнаар улиралдаа 1 удаа ариутгал хийгддэг

9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хийгдээгүй.

10. Аймаг, сумын Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ

№	Хийсэн ажилууд	Мөнгөн дүн (төг)
СУМЫН ХӨГЖИЛД		
1	Даланжаргалан сумын дулааны шугам хоолой сантехникийн засварын зураг төсөв хийлгэсэн	7 500 000
2	Даланжаргалан сумын хогийг цэвэрлэж, дарж булшилсан	15 500 000
3	Сумын 100 жилийн ойд	5 000 000
СУМЫН СОЁЛ УРЛАГ, СПОРТ, ТҮҮХТ ҮЙЛ АЖИЛЛАГААНД		
3	Хонгорын овоо тахих үйл ажиллагаа	2 000 000
4	Даланжаргалан сумын наадмын үйл ажиллагаа	1 500 000
5	Бичигт багийн соёлын төвийг хүлээн авах арга хэмжээ	1 000 000
6	Волойболын эрэгтэй эмэгтэй тамирчдын зардал	2 000 000
7	Шагайн харвааны тэмцээнд явах зардал	500 000
МАЛ АЖ АХУЙГ ДЭМЖСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА		
8	Бичигт багийн малчдад өвс тэжээлийн тусламж сумаар дамжуулан	6 000 000
9	Малын хөрзөн ховхлох арга хэмжээ	3 000 000
10	Малын гоц халдварт өвчин устгах	1 000 000
11	Сэг зэм устгал	1 500 000
НИЙГЭМ, БОЛОВСРОЛ		
11	Бичигт багийн өндөр настанд хүндэтгэл үзүүлж, цагаан сарын мэндчилгээ дэвшүүлсэн	2 000 000
12	Оюутны сургалтын зардал	5 000 000
13	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслах арга хэмжээ	4 000 000
14	Хонгорт өвөлжсөн Аргал угалзанд өвс тэжээл	500 000
Нийт		58 000 000

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжүүлсэн
Байгаль орчныг хамгаалах тухай хуулын 10 ¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд хийлгэх	Тусгай зөвшөөрлийн талбайд	2024 онд “Энвайроментал комплайнц” ХХК-р хийлгэсэн /Хавсралт материал 2/
Газрын төлөв байдал, чанарын хянан хянан байталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Тусгай зөвшөөрлийн талбайд	Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны мэргэжлийн компаниар 2020 онд хийлгэсэн

ХАВСРАЛТ ЗУРАГ



Зураг 1. Замын арчилгаа усалгаа



Зураг 2. Анхааруулах тэмдэг тэмдэглэгээ



Зураг 3. Автомашинаас гарах хорт утааг багасгах шүүлтүүр



Уурхайн орчим тарьсан мод




Зураг 4. Бутлуурын талбайд тарьсан модны ургалт



Зураг 5. Үндсэн болон шимт хөрсний овоолгууд



Зураг 6. Худгийн тоолуур, баталгаажуулалтын гэрчилгээ



Зураг 7. уурхайгаас баруун урд байрлалтай Нүдэнгийн худгийн хэмжилтийн явц



Зураг 8. Ундны худгийн эрүүл ахуйн хамгаалалтын байр



Зураг 9. Зэрлэг амьтдад өвс тэжээл тавьсан нь



Зураг 10. Галын хамгааллын багаж хэрэгсэл



Зураг 11. Шатах тослох материалын хадгалалт



Зураг 13 . Хог хаягдлыг түр хадгалах цэг



Зураг 12. Хог хаягдлын ангилан ялгалт



Зураг 14. Ахуйн хог хаягдлыг хог хаягдлын нэгдсэн цэгт нийлүүлэлт



Зураг 15. Шинээр баригдаж буй ариун цэврийн байгууламж

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 1



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/528

Сайншанд сум

Тусгай зориулалтын авто замын чиглэл батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.21 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.1.8 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор батлагдсан "Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Айраг сумын Нард багийн нутагт орших MV-017256 дугаартай "Хонгор-3" нэртэй ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас олборлосон жоншийг Айраг өртөөний ачилт, буулгалтын талбай хүртэл тээвэрлэлт хийх "Хүдрэнт" ХХК-ийн 26.5 км тусгай зорилалтын авто замын чиглэлийн солбицлын цэг, байршил зургийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан чиглэлийн дагуу замын арчлалт хамгаалалтыг тогтмол хийж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, уртын тээврийн жолооч нарын тээвэрлэлтийг хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулж, ачаа тээвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгэн ажиллахыг "Хүдрэнт" ХХК-д үүрэг болгосугай.

3. Батлагдсан чиглэлийн дагуу бүтээгдэхүүн тээвэрлэлтийн замын хөдөлгөөний зохион байгуулалтад хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Б.Батзориг), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Н.Отгонбаяр), Дорноговь аймгийн Авто тээврийн төв (Ж.Сүхбаатар), Айраг сумын Засаг дарга (С.Жаргалсайхан) нарт, батлагдсан чиглэлийг зураглалд оруулж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын газар (Ц.Оюунсайхан)-т тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ц.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О. БАТЖАРГАЛ



• 44 24 1 1800

2024 оны 06 дугаар сарын 25
 2028 оны 06 дугаар захирамжийн хавсралт
 Аймгийн Засаг даргын
 25 ны өдрийн

"ХҮДРЭНТ" ХХК-ийн тусгай зориудалтын 26.5 км
 АВТО ЗАМЫН ЧИГЛЭЛИЙН СОЛБИЦОЛ. ЗУРАГЛАЛ

№	Авто замын түр чиглэлийн солбицол					
	Х			У		
	градус	минут	сек	градус	минут	сек
1	2	3	4	5	6	7
1	45	47	53.50	108	59	5.8
2	45	48	1.80	108	59	52.4
3	45	48	3.28	109	0	31.53
4	45	48	15	109	1	40.89
5	45	47	47.7	109	2	54.1
6	45	47	29	109	4	27.5
7	45	47	9.9	109	5	56.3
8	45	47	27.9	109	7	27
9	45	47	42.7	109	8	59.8
10	45	47	42.9	109	9	41.9
11	45	47	18.4	109	10	9.6
12	45	47	28.2	109	11	45.5
13	45	47	37.3	109	12	46.6
14	45	47	19.9	109	13	8.6
15	45	47	5.4	109	14	29.6
16	45	47	6	109	16	3.1
17	45	47	29.2	109	17	49.3
18	45	47	57.1	109	18	10.9
19	45	48	8.5	109	18	5.3



ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 2.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
НИЙЦЛИЙН ХӨНДЛӨНГЭЙН АУДИТ
Аудитын тайлан № БАТ2024/09



БАЙГАЛЬ ОРЧНЫ
АУДИТ

Байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийн аудит

Аудитын тайлантай танилцаж хүлээн авсан:

Нэр	Албан тушаал	Гарын үсэг

2024 он

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН №	БОЛОВСРУУЛСАН ОГНОО
----------------------	---------------------

EAR2024/09

2024.07.05

ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА	ЗАХИАЛАГЧ ХАЯГ	БАЙГУУЛЛАГЫН
-----------------------	-------------------	--------------

ХҮДРЭНТ ХХК

АУДИТ ХИЙХ ТӨСӨЛ	АУДИТ ХИЙХ БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ
------------------	---------------------------------

“Хонгор” төслийн талбай

Дорноговь аймгийн
Даланжаргалан сум

АУДИТЫН ТӨРӨЛ	АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:
---------------	-----------------------

Байгаль орчны нийцлийн аудит

Байгаль орчны хууль тогтоомж
болон БОННУ-ний хэрэгжилтийн
биелэлт

АУДИТЫН ХЯЗГААРЛАХ ХҮРЭЭ	АУДИТЫН ШАЛГУУР
--------------------------	-----------------

БО-ноос бусад хууль тогтоомж

Байгаль орчны багц хууль,
журмууд болон БОННУ-ний
заалтууд

АУДИТ ХИЙСЭН ХУГАЦАА:	ӨМНӨХ ХУГАЦАА	АУДИТ	ХИЙСЭН
-----------------------	------------------	-------	--------

2024 оны 05-р сарын 26-с 07-р сарын
05-ны өдөр

2 дахь

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хүдрэнт ХХК-ийн “Хонгор” жоншны уурхайн төслийн үйл ажиллагаанд “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” –ийн 10¹ дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчны багц хуулиуд тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, тогтоол, байгаль орчны стандартуудын заалтуудын нийцлийн аудитыг 2024 оны 05-р сарын 26-с 07 сарын 05-ны өдрүүдийн хооронд хийж гүйцэтгэв.

Тус байгаль орчны аудитыг төслийн БО-ны баримт бичгүүдийн хяналт, төслийн талбай дээрх шалгалт, холбогдох ажилтнуудтай хийсэн ярилцлага болон цуглуулсан баримт нотолгоо дээр үндэслэн аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулах зэрэг үндсэн үйл ажиллагааны дагуу хийв.

Хүдрэнт ХХК-ийн “Хонгор” жоншны уурхайн жоншны уурхайн төслийн үйл ажиллагаа эхлээд 5 жил болж байгаа бөгөөд Байгаль орчны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажилд хэрхэн анхаарал хандуулж ажилладаг болохоо шалгуулахаар байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэж аудитын дагуу арга хэмжээ авч засаж сайжруулсан байгаа нь байгаль орчны асуудалд ач холбогдол өгч байгааг илэрхийлэх сайшаалтай явдал юм.

Төслийн үйл ажиллагаанууд нь хууль эрх зүйн хувьд нийт 22 хуулийн 285 зүйл заалтаас төслийн үйл ажиллагаатай хамаарал бүхий 176 зүйл заалтаас нийцлийн 155 заалт буюу 88,1%, үл нийцэл 7 заалт буюу 3.98%, тодорхойгүй 14 заалт буюу 7.95% байлаа. Энэхүү үзүүлэлт нь 2020 оныхоос сайжирсан үзүүлэлт болно.

Үл тохиролд орсон заалт нь хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд Экологийн паспорт хөтлөх, агаарын чанарын дотоод хяналт хийгээгүй, газар эзэмших гэрээг байгуулснаас хойш жил бүр дүгнүүлэх шаардлагатай байдгийг хэрэгжүүлээгүй, тээвэрлэх эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулаагүй зэрэг асуудлууд байгааг анхаарч ажиллахыг зөвлөө.

Аудитын хугацаанд үйлчлүүлэгч байгууллагын холбогдох ажилтнууд дэмжин хамтран ажилласан бөгөөд ямар нэгэн саад тогтор, хөндлөнгөөс нөлөөлөх байдал гараагүй болно.

Гарын үсэг:



Б.Энхбаяр, Ахлах аудитор

Огноо: 2024.07.05

Байгаль орчны аудитын зөвлөмж

Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг сумдын нутагт орших Хүдрэнт ХХК-ийн "Хонгор" жоншны уурхайн төслүүдэд аудит хийхэд явцад илэрсэн үл тохирол ба эдгээр үл тохирлыг хэрхэн засах, аудитын явцад хийж гүйцээгүй болон хийгдэж байгаа арга хэмжээнүүдэд дараах зөвлөмжүүдийг өглөө. Энэхүү зөвлөмжид зарим авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд багтсан болно. Үүнд:

1. Экологийн паспорт хөтлөх /MNS.4219:1994 Байгаль орчныг хамгааллын стандартын систем. Аж ахуйн нэгжийн экологийн паспорт. Үндсэн дүрэм/ стандартыг худалдаж аваад стандартын дагуу Экологийн паспорт хөтлөх
2. Газрын тухай хуулийн 34.8-д заасны дагуу Газар эзэмших гэрээг талууд жил бүр дүгнэх шаардлагатай байдаг тул газрын даамалтай байгуулсан гэрээг жил бүр дүгнүүлэн гэрээг шинэчлэн байгуулж байх
3. Агаарын чанарын дотоод болон гадаад хяналт (орчны хяналт шинжилгээний хөтөлбөр) явуулахдаа аймгийн УЦУОШГ-тай гэрээ байгуулан жилд 2 удаа төслийн талбайд агаарын чанарын хэмжилт хийлгэж байх
4. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын засаг даргатай гэрээ байгуулсан хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, устгах эрх бүхий аж ахуйн нэгжтэй хог хаягдал тээвэрлүүлэх гэрээг байгуулан хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлөх.
5. Төслийн талбайд ажиллаж байгаа ажилтнуудад хог хаягдлыг ангилан ялгах талаар сургалт хийж, хог хаягдлыг ангилан ялгаж хаях дадлыг хэвшүүлэх. Хогийн цэгийг хог хаягдал ангилан хаях зориулалттай болгон тохижуулах.
6. Газрын тухай хуулийн 58.5-д заасны дагуу 5 жил тутамд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хийлгэх шаардлагатай байдаг тул 2019 онд хийгдсэн хянан баталгааны хугацаа 2024 онд дуусаж байгаа тул шинэчлэн хийлгэх

Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлээд тухайн хэрэгжүүлсэн тайлангаа дараагийн төлөвлөгөөт аудит хийгдэхээс өмнө орон нутгийн байгаль орчны албанд хүргүүлэх.

Б.Энхбаяр

Ахлах аудитор,

Энвайроментал комплайнц ХХК-ийн Захирал

2024.07.05



ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 3.



Орон нутгийн өмчийн III байр, Залуучуул сууцны,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 3663, факс: (02-522) 4-27-26
Хаяг: Дорноговь-Орчин, Дорноговь аймаг
Цахилгаан: www.dornogov.gov.mn

2024. 07. 04 № 216

тантай -ны № -т

"ХҮДРЭНТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Б.МӨНХБАТ ТАНАА

Танай 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 06/24 тоот албан бичгээр ирүүлсэн 2024 оны Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн 2024 оны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлээ.

Хавсралт хуудастай.

Хувийг Аймгийн Татварын хэлтэс,
Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газарт

ДАРГА



Н.ОТГОНБАЯР

4424230388

ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР 2024 ОНЫ УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2024 оны 07 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар-34

Сайншанд хот

1.Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар:

"Хүдрэнт"ХХК-ны захирал Б.Мөнхбат, Улаанбаатар Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 8-р байр, утас: 99112691, 94099260, Улсын бүртгэлийн дугаар 9011054065, регистрийн дугаар 2732521

2. Төслийн нэр, байршил:

Дорноговь аймаг Даланжаргалан сумын нутагт байрлах "Хонгор-3" хайлуур жоншны орд

3. Төсөл хэрэгжүүлэгч: "Хүдрэнт" ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X,Y/: MY-017256, 24,93 га

X	Y
108° 59' 6.67"	45° 47' 46.61"
108° 58' 44.67"	45° 47' 46.61"
108° 58' 44.67"	45° 48' 3.62"
108° 59' 6.67"	45° 48' 3.62"

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:

Хайлуур жоншны орд ил, далд аргаар ашиглана.

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:

Хөрс хуулалтын ажилд Shantui SD 13 бульдозер, Hyundai 2900 LC-7 болон 4700 JC-7 маркийн экскаватор, 2,7м³ -ийн утгуурын багтаамжтай XCMG SEM 650B маркийн утгуур ачигч, 25 тн -ийн тээвшний багтаамжтай HOWO 290 маркийн автосамосвал зэрэг машин техник ажиллана. 2024 оны 05 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл жилд ажлын 196 хоног, 2 ээлжээр, ээлжинд 12 цагаар 34 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллана.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:

2024 онд ил уурхайн төлөвлөлтөөр ордоос 75,83% агуулгатай 25,5 тн хүдэр олборлохоор төлөвлөсөн.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/:

Усны эх үүсвэр нь Умард говийн гүвээт халхын дундад талын сав газар. 2015 онд гаргасан гүн өрмийн худагтай. /Цооногийн гүн 100 м, Усны ундрага 5,8 л/сек/ Худгийн барилга байгууламжтай.

9.Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/:

Мэдээлэл байхгүй.

10.Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /нэвсэсний хүчин чадал, марк/:

Тоолуур суурилуулсан.

11. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/:

12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:

Ахуйн хаягдал бохир усыг хөрсөнд шингээн зайлуулдаг.

13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2022 онд "Дөрвөн талст экологи" ХХК-иар хийлгэсэн.

14. Онцгой нөхцөл:

15. Холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандарт, баримт бичгийн дагуу усны зарцуулалтыг тооцох

Байгаль орчны сайдын 2015 оны А/301 дугаар тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны түр норм"-ын дагуу тооцоход

34 хүн х 20л/хон х 196 хон=134,0м³/жил – үнд ахуйн усны хэрэглээ

50ш х 45л х 84 удаа= 189,0м³ – ногоон байгууламжийн усалгаа

14000,0м х 4.0м х 2л/м² х 1удаа/хон х 196,0 хон = 21952,0м³-зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус

Нийт: 134,0м³+189,0м³+21952,0м³= 22275,0м³ жилд ашиглана.

16. Зам талбайн тоосжилт дарах 21952,0м³, Ногоон байгууламжийн усалгаанд ашиглах 189,0м³, ашиг олох зориулалтаар ашиглах 134,0м³ нийт усыг газрын доорх усны төлбөрийн хэмжээг "Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор "Умард говийн гүвээт- Халхын дундад талын сав газар"-т тогтоосон газрын доорхи усны экологи-эдийн засгийн суурь үнэлгээ, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолоор тогтоосон ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1-р хавсралтын 7а, 9-д заасан усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг үндэслэн тооцож, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг "Төсвийн тухай" хуулийн 23.6.5-д заасны дагуу аймгийн Төрийн сангийн ...тоот дансанд төвлөрүүлэх;

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолыг үндэслэн ус ашигласны төлбөрийг тооцвол:

- "Умард говийн гүвээт- Халхын дундад талын сав газар"-т газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи-эдийн засгийн суурь үнэлгээ 3700 төг/м³ байна.

- 10 хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 9-д заасан хувь хэмжээ.

- 0.20- ашиглах усны ашиглалтын зориулалтын итгэлцүүр

- 378.0м³ жилд – ногоон байгууламжийн усалгаа

189,0м³ х 74.0 = 13986,0 төг /арван гурван мянга есөн зуун наян зургаан төгрөг/

- "Умард говийн гүвээт- Халхын дундад талын сав газар"-т газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи-эдийн засгийн суурь үнэлгээ 3700 төг/м³ байна.

- 20 хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 7а-д заасан хувь хэмжээ.

- 0.25- ашиглах усны ашиглалтын зориулалтын итгэлцүүр

- 6600.0м³ жилд – зам талбайн тоосжилт дарах

21952.0 м³ х 185 төг=4061120,0 төг /дөрвөн сая жаран нэгэн мянга нэг зуун хорин төгрөг/

- "Умард говийн гүвээт- Халхын дундад талын сав газар"-т газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи-эдийн засгийн суурь үнэлгээ 3700 төг/м³ байна.

- 15 хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 7а-д заасан хувь хэмжээ.

- 0.16- Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу ашиг олох зориулалтаар ашиглах газрын доорхи усыг ашиглахад тооцох ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр

$134,0 \text{ м}^3/\text{жил} \times 88,8 \text{ төг}/\text{м}^3 = 11900,0 \text{ төг} / \text{арван нэгэн мянга есөн зуун төгрөг}$

Нийт: $13986,0 \text{ төг} + 4061120,0 \text{ төг} + 11900,0 \text{ төг} = 4087006,0 \text{ төг} / \text{дөрвөн сая наян долоон мянга зургаан төгрөг}$

17. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар:
Хэрэглээнээс гарсан бохир усыг "Усны чанар. Хүрээлэн бие орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага" MNS 4943:2011 стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж ногоон байгууламжийн усалгаанд ашиглах.

18. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

- Ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Даланжаргалан сумын Засаг даргын захирамжаар ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулах /"Усны тухай" хуулийн 28.6-р зүйл/
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах
- Усны шинжилгээг хийлгэж дүнг ирүүлэх
- Тоолууржуулан баталгаажсан тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож байх /Усны тухай хуулийн 30.1.4-д усны эх үүсвэрийг /БОНХС-ын 2013 оны А-156 тоот тушаалаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"/
- "Аж ахуйн нэгжийн экологийн паспорт" хөтлөх /Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл, Стандартчилал хэмжилзүйн хэлтэсээс авах/
- Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч ажиллах /Усны тухай хуулийн 31.2-р зүйл/
- Ус ашиглах зөвшөөрлийн хураамжийг Даланжаргалан сумын Төрийн сан банкны 060300995 тоот дансанд тушааж хуулбар хувийг ирүүлэх /Монгол Улсын "Улсын тэмдэгтийн хураамжийн тухай" хуулийн 21.1, 20-р зүйл, Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2011 оны 51-р тогтоол/
- Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс болох 50 000 төгрөгийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Төрийн сан банкны 100 060013001 дансанд тушааж /Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А-376 тоот тушаал/
- Зөвлөмжид заасан ажлын тайлан, Ус ашиглалтын мэдээ тайланг 11-р сарын 05-нд багтаан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлэх

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА:



Ш. АМГАЛАНСАЙХАН

Н. ОТГОНБАЯР

